

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 12 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны долоодугаар сарын 25-ны 15 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 25 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Б.Алтантөгсийн удирдах ажилтны сонгон шалгаруулах комисст гаргасан өргөдлийг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	Зоонозын өвчин судлалын төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Базарваань овогтой Алтантөгс нь 61,1 оноо авч тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.
2	М.Цолмонбаярын өргөдлийг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	Биеийн тамир, спортын газрын даргын “М.Цолмонбаярыг ажлаас чөлөөлөх тухай” 2017 оны 05 сарын 25-ны өдрийн Б/04 дүгээр тушаалд дурьдсан М.Цолмонбаяр нь удирдлагын зүгээс арга хэмжээ авсаар байтал ажлын байранд архидан согтуурч, төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын дотоод журмыг зөрчих үйлдлийг давтан гаргасан болон дээрх тушаал нь хууль зүйн үндэслэлтэй гарсан тухай Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй үзсэн тогтоол гаргахаар болов.
3	Төрийн албаны тэргүүний ажилтанд тодорхойлосон Ч.Оюунсайханы тухай	Төрийн албанд олон жил идэвх санаачлагатай ажиллаж, хөдөлмөрийн амжилт гаргасан аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч, архивын ажилтан Чимэдцогзол овогтой Оюунсайханы тодорхойлолтыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөр хэлэлцэн, түүний хөдөлмөр бүтээлийг үнэлж, “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар шийдвэрлэж, материалыг ТАЗ-д хүргүүлэхээр болов.
4	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийн 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилт	Хуралдааны шийдвэрийн 2017 оны эхний хагас жилд 11 хуралдаанаар 48 асуудал шийдвэрлэснээс хэрэгжилт 100%-35, 90%-13 хэрэгжилтийн хувь 97,29 байна гэж үзлээ. Зарим байгууллагуудаас албан тоотын хариуг хцгацаанд нь ирүүлэхгүй байгаад хариусан салбар зөвлөлийн гишүүд анхаарч ажиллахыг үүрэг болголоо.
5	ИТХ-ын ажлын албаны тогтоол шийдвэр, төрийн шагнал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны Тогтоол шийдвэр, төрийн шагнал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Шаравжамц овогтой Оюуныг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА